

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ГЭЖ ЮУ ВЭ

ХУУЛЬ ГЭЖ ЮУ ВЭ?

Хууль гэдэг ойлголт нь бүх нийт заавал дагаж мөрдөхөөр төрөөс батлан гаргаж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон дээд хүчин чадал бүхий баримт бичгийг хууль гэнэ. Хууль нь эрх зүйн илрэх гадаад хэлбэр бөгөөд хууль, эрх зүй хоёр нь зоосны хоёр талтай адил юм. Эрх зүйн хэм хэмжээг тогтоогч хүчин зүйл нь хууль юм.

Эрх зүй нь үндсэндээ "тогтоосон", "зөвшөөрсөн", "хориглосон" гэсэн гурван хэм хэмжээгээр нийгмийн харилцааг нэг талаас зохицуулж, нөгөө талаас хамгаалж байдаг. Энгийн утгаар авч үзвэл зохицуулах үүрэг нь: тогтоосон, зөвшөөрсөн хэм хэмжээгээр илүүтэй илэрдэг бол хамгаалах үүрэг нь: хориглосон хэм хэмжээгээр тодорхойлогддог байна

Эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэдэг байна.

Эрх зүйн хэм хэмжээний чадлыг тодорхойлдог хамгийн чухал шинжийг хууль зүйн хариуцлага гэж хэлж болно. Төрөөс тогтоосон эрх зүйн хэм хэмжээ зөрчигдсөн тохиолдолд тухайн зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх хариуцлага нь хууль зүйн дагуу байх ёстой. Өөрөөр хэлбэл, хэмжээ нь хуульчлагдсан байх бөгөөд хуульд заагдаагүй хариуцлагыг иргэнд хүлээлгэх боломжгүй байдаг.

Хууль зүйн хариуцлагын үндсэн дөрвөн төрөл байдаг. Үүнд:

1. Иргэний эрх зүйн буюу эд хөрөнгийн хариуцлага
2. Эрүүгийн хариуцлага
3. Захиргааны хариуцлага
4. Сахилгын хариуцлага

Дээрх хариуцлагын төрөл тус бүр нь өөр өөрийн хууль тогтоомжид тусгалаа олсон байдаг.

Зөвхөн хуульд заасан хариуцлагыг хуулиар эрх олгогдсон албан тушаалтан, хуульд заасны дагуу хүчин төгөлдөр шийдвэрийн үндсэн дээр оногдуулдаг байна. Хууль зүйн хариуцлага нь төрийн албадлагаар хэрэгждэг.

Бидний амьдралд хууль нөлөөлөх нь

1. Нийгмийн харилцааны амар амгалан, тайван байдлыг хамгаална.
2. Төрийн эрх мэдлийг тэнцвэржүүлж, хяналт тавин, иргэний эрх чөлөөг баталгаажуулна.
3. Шударга өрсөлдөөнийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг бий болгоно.
4. Нийгмийн шударга ёс, тэгш байдлыг хангана.
5. Хүрээлэн буй орчныг хамгаална.

ЭРХ ЗҮЙ ГЭЖ ЮУ ВЭ?

Эрх зүй гэдэг ойлголт нь: Хүний эрх, эрх чөлөө, шудрага ёсны шаардлагыг хангаж, нийгмийн харилцааг зохицуулах зорилгоор төрөөс тогтоож зөвшөөрсөн, төрийн засаглалын хүч дэжмлэгээр хамгаалагдсан, заавал биелэгдэх, зан заншил хууль зүй, ёс суртахууны зүй зохистой, хэм хэмжээт үйлчлэн зохицуулагч систем юм.

Эрх зүй нь янз бүрийн давхаргын ашиг сонирхол, нийгмийн шударга ёсны шаардлагыг илэрхийлж, нэг талаас нийгмийн хэсэг бүлгийн бус нийгмийн нийтлэг ашиг сонирхолд үйлчлэх, нөгөө талаас хувь хүний хэрэгцээ ашиг сонирхолыг харгалзан зохицуулсан хэм хэмжээний тогтолцоо юм.

Эрх зүйг ойлгох ойлголт, түүнд хандах хандлага нь хүн төрөлхтний түүхэн хөгжлийн үе шат, улс орны хөгжлийн үндсэн чиг, шинжлэх ухааны хөгжил, дэвшлийн нөлөөгөөр өөрчлөгдсөөр иржээ.

Эрх зүйгүйгээр соёл иргэншилт нийгэм оршин тогтнох бололцоогүй. Энэ нь нийгмийн зайлшгүй үзэгдэл юм.

Иргэний эрх зүйн үндсэн ойлголт:

1. Иргэний эрх зүйн харилцааны оролцогч нь: Иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна.
2. Хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг хуулийн хэм хэмжээг нөхөн зохицуулсан тохиолдолд хэрэглэнэ.
3. Иргэний эрх зүйн бүрэн чадамж нь Монгол улсад 18 наснаас үүснэ.
4. Иргэдийн иргэний эрх зүйн чадварыг хязгаарлахыг хориглоно
5. Иргэний эрх зүйн чадамж нь хязгаарлагдсан этгээд хязгаарлагдахгүй чадамжийнхаа хүрээнд харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр хэлцэл хийж болно.

Эх сурвалж Ц.Баасандожийн нийтлэлээс